


БАТЛАВ.
АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА




Ж.ЦОЛМОН

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙН ҮЕД АЮУЛТАЙ АЧААНЫ
ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ ЖУРАМ

Баримт бичгийн код	АХОЗШША - 25-06		
Баталсан огноо:	2025 он- 11 сар- 09 өдөр		
Хянасан:	Албан тушаал, нэр	Огноо	Гарын үсэг
	Х. Наранхүү	2025. 11. 08	
Боловсруулсан:	Албан тушаал, нэр	Огноо	Гарын үсэг
	У. Буяндаграв	2025. 11. 08	

Өөрчлөлтийн бүртгэл

Өөрчлөлтийн дугаар	Өөрчлөлтийн товч тайлбар	Өөрчлөлт оруулах хэсэг	Өөрчлөлт хийсэн ажилтны нэр, албан тушаал	Огноо	Гарын үсэг
1	Шинэ хууль, дүрэм	Бүгд	Шинжлэн шалгагч	2025. 11.01	
2					
3					

Түгээлтийн жагсаалт

№	Баримт бичиг	Хэнд (түгээх нэгж/байгууллага)
1	Журам	Шинжлэн шалгагч нарт
2		
3		

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙН ҮЕД АЮУЛТАЙ АЧААНЫ ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар Чикагогийн конвенцын Хавсралт-13-ын 4.7, 4.11 дэх заалт, Дос 9962 5.4.3 заалт, Осол, зөрчлийг шинжлэн шалгах дүрэм, Осол, зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагааны зааврын дагуу Монгол улс болон гадаад улсын нутаг дэвсгэрт гарсан Монгол улсад бүртгэлтэй, Монгол улсын тээвэрлэгчийн осолд орсон агаарын хөлгийн аюултай ачааны талаарх мэдээллийг дамжуулах ажиллагааг зохицуулна.

ХОЁР. АЮУЛТАЙ АЧААНЫ ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ

2.1. Мэдэгдэл хүлээн авсан улс нь аль болох хурдан хэлбэрээр агаарын хөлөгт байгаа аюултай ачааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг гүйцэтгэгч улсад илгээнэ.

2.2. Мэдэгдэл хүлээн авмагц үйл ажиллагаа эрхлэгчийн улс хамгийн бага сааталтайгаар, хамгийн тохиромжтой болон хамгийн хурдан арга хэрэгслээр агаарын хөлөгт байгаа аюултай ачааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэсэн улсад өгнө.

2.3. ИКАО-ын Аннекс 13-ын 4-р бүлгийн дараах тодорхой шаардлагууд нь АХОЗШША-ны баримтлах бодлогын заалт мөн:

- Монгол улсад осол, зөрчил гарснаас хойш аль болох түргэн бусад оролцогч улсууд болон ИКАО-д осол, зөрчлийн мэдэгдэл хүргүүлэх, мөн анхан шатны мэдэгдэлд дутуу байсан мэдээлэл болон дараа нь тодорхой болсон бусад хамааралтай мэдээллийг нэмэлтээр илгээх.

- Мэдэгдлийг боломжит бүх мэдээлэлтэйгээр цаг алдалгүй, ойлгомжтой, товч хэлбэрээр ИКАО-гийн албан ёсны ажлын хэлнүүдийн аль нэгээр (ихэвчлэн англи хэлээр) үйлдэж хүргүүлэх.

- Бусад улсаас ирүүлсэн осол, зөрчлийн мэдэгдлийг хүлээн авснаа баталгаажуулж хариу мэдэгдэх.

- Шинжлэн шалгах ажиллагааг явуулж буй улсад тухайн осол, зөрчилтэй холбоотой нислэг, нисэх баг, агаарын хөлгийн талаарх холбогдох мэдээллийг боломжит хэмжээнд аль болох шуурхай хүргүүлэх.

- Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох эсэх, томилох бол аялал болон бусад зохион байгуулалтын мэдээллийг мэдэгдэх.

- Агаарын хөлөг дээр аюултай ачаа байсныг АХОЗШША мэдэж байгаа бол шинжлэн шалгах ажиллагааг явуулж буй улсад аюултай ачааны дэлгэрэнгүйг хамгийн тохиромжтой бөгөөд хамгийн хурдан аргаар нэн даруй мэдэгдэнэ.

2.4. Агаарын хөлгийн осол, зөрчлийн талаарх мэдэгдлийг хүлээн авахын тулд 24 цагийн байнгын ажиллагаатай жижүүрийн үүргийг албаны дарга ерөнхий

шинжлэн шалгагчийн баталсан хуваарийн дагуу бие бүрэлдэхүүн ээлжээр гүйцэтгэнэ.

2.5. Агаарын хөлгийн аюултай ачааны талаар мэдээллийг хамгийн бага саатал, хамгийн тохиромжтой, хамгийн хурдан хэрэгслээр дамжуулах үүрэгтэй жижүүр нь мэдээлэл хэзээ ирсэн цаг хэнээс хүлээж авсан ямар арга хэмжээ авснаа дэлгэрэнгүй хөтөлнө.

2.6. Ажлын байрны бэлтгэл:

- Мэдээлэл хүлээн авах утас факс электрон шуудан
- Мэдээллийг бүртгэх дэвтэр
- Мэдээлэл түгээх албан тушаалтан байгууллагын утас /нутаг олон улс/

2.7. Агаарын хөлгийн осол, зөрчилтэй холбоотой аливаа мэдээлэлд доорхи мэдээллүүдийг хамруулна.

- Агаарын хөлгийн аюултай ачааны талаар мэдээлэл
- Агаарын хөлгийн ослын талаархи мэдээлэл
- Агаарын хөлгийн тоног төхөөрөмж системүүдийн доголдол дутагдал
- Хөндлөнгийн хууль бус үйлдлийн талаар мэдээлэл

2.8. Агаарын хөлгийн аюултай ачааны талаар мэдээллийг хүлээн авсан жижүүр албан тушаалтан доорх хаягаар Хавсралт Б маягтыг яаралтай бөглөн албаны даргад танилцуулна.

2.9. Албаны даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу албан тушаалтан шинжээчид мэдэгдэх ба холбогдох газар улсуудад үйл ажиллагааны зааврын 4.2 дагуу мэдээлэл явуулна.

2.10. Томилогдсон албан тушаалтан, шинжлэн шалгагч нь Агаарын хөлгийн осол, зөрчлийн үед дараах мэдээллийг өгнө.

А) агаарын хөлгийн осол эсвэл

Б) Агаарын ачаагаар тээвэрлэж буй аюултай ачаатай холбоотой ноцтой зөрчил.

2.11. Агаарын хөлгийн оператор нь осол, ноцтой зөрчил гарсантай холбогдуулан нислэгийн өмнө хөлгийн даргын мэдүүлсэн аюултай ачааны мэдээллийг яаралтай бичгээр авч нэн даруй АХОЗШША-д дамжуулах ёстой.

2.12. Хөлгийн даргын үлдээсэн мэдээлэл:

- Оператор улсын болон осол, ноцтой хэрэг гарсан улсын холбогдох байгууллагад аль болох хурдан мэдээлэл өгөх

- Агаарын хөлгийн ослын үед аюултай ачааг агаарын ачаа болон тээвэрлэж буй агаарын хөлгийн оператор нь тухайн агаарын хөлгийн даргын бичгээр өгсөн мэдээлэлд тусгагдсан агаарын хөлөгт байгаа аюултай ачааны дэлгэрэнгүй мэдээллийг тухайн осолд холбогдсон онцгой байдлын алба болон тухайн улсын холбогдох байгууллагад хүсэлтийн дагуу нэн даруй дамжуулна. Жич "осол", "ноцтой зөрчил" "зөрчил" гэсэн нэр томъёог Хавсралт 13-т тодорхойлсноор бичнэ.

– Аюултай ачааг агаарын тээврээр олон улсад тээвэрлэхийг зохицуулах ерөнхий заалтууд Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцийн 18-р хавсралт, “Аюултай ачааг агаарын тээврээр аюулгүй тээвэрлэх” гэж заасныг мөрдөнө.

2.13. Аюултай ачаа тээврийн осол, зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Хэлэлцэн тохирогч улс бүр өөрийн нутаг дэвсгэрт гарсан, өөр улсаас гаралтай эсвэл өөр улс руу чиглэсэн аюултай ачаа тээвэрлэлттэй холбоотой ийм осол, зөрчлийн талаарх мэдээллийг шинжлэн шалгах журмыг тогтооно.

2.14. Ачаанд мэдүүлээгүй эсвэл буруу мэдүүлсэн аюултай ачааны тохиолдлыг давтахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Хэлэлцэн тохирогч улс бүр өөрийн нутаг дэвсгэрт гарсан, өөр улсаас гаралтай эсвэл өөр улс руу чиглэсэн аюултай ачаа тээвэрлэлттэй холбоотой ийм тохиолдлын талаарх мэдээллийг шинжлэн шалгах журмыг тогтооно.

2.15. ИКАО-той мэдээлэл солилцохдоо доорх хаягаар харьцаж болно.

Олон улсын иргэний нисэхийн байгууллага
Customer Services Unit
999 University Street 8 Montreal, Quebec, Canada H3C 5H7
Tel: + 514-954-8022
Fax: +514-954-6769
Email: sales@icao.int
Internet home page: www.icao.int

----oOo----

МЭДЭЭЛЭЛ ИЛГЭЭХ МАЯГТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1	Тайлангийн дугаар		11	Огноо	
2	Тайлангийн төрөл	<input type="checkbox"/> Урьдчилсан тайлан <input type="checkbox"/> Ослын өгөгдлийн тайлан <input type="checkbox"/> Зөрчлийн өгөгдлийн тайлан	12	Цаг	
3	Тохиолдлын төрөл	<input type="checkbox"/> Осол <input type="checkbox"/> Ноцтой зөрчил <input type="checkbox"/> Зөрчил	13	Газар	
4	Улс		14	Нислэгийн дугаар	
5	Агаарын хөлгийн төрөл, загвар		15	Бүртгэлийн дугаар	
6	Хөөрөлтийн дээд жин		16	Үйл ажиллагаа эрхлэгч	
7	Бүртгэлийн улс		17	Үйл ажиллагаа эрхлэгч улс	
8	Зохион бүтээгч улс		18	Үйлдвэрлэгч улс	
9	Шинжлэн шалгах ажиллагаа явуулсан улс	Монгол Улс	19	Хариуцсан байгууллага	
10	Хариуцсан ажилтан		20	Холбоо барих мэдээлэл	

II. ХАМААРАХ АНГИЛАЛ

№	Ангилал	Сонголт
1	2,250 кг-аас дээш жинтэй агаарын хөлгийн осол	<input type="checkbox"/>
2	2,250 кг буюу түүнээс бага жинтэй агаарын хөлгийн осол, нислэгт тэнцэх чадвар болон нийтлэг сонирхлын асуудал хөндөгдсөн	<input type="checkbox"/>
3	5,700 кг-аас дээш жинтэй агаарын хөлгийн зөрчил	<input type="checkbox"/>

III. ХҮРГҮҮЛЭХ ЭТГЭЭД

№	Хүлээн авагч	Хүргүүлэх эсэх	Огноо	Арга хэлбэр тайлбар
1	Бүртгэлийн улс	<input type="checkbox"/>		
2	Үйл ажиллагаа эрхлэгч улс	<input type="checkbox"/>		
3	Зохион бүтээгч улс	<input type="checkbox"/>		
4	Үйлдвэрлэгч улс	<input type="checkbox"/>		
5	Мэдээлэл, чухал ач холбогдолтой боломж, эсхүл шинжээчээр хангасан улс	<input type="checkbox"/>		
6	ICAO	<input type="checkbox"/>		

IV. ТОХИОЛДЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

№	Үзүүлэлт	Мэдээлэл бөглөх хэсэг	Үзүүлэлт	Мэдээлэл бөглөх хэсэг
1	Тохиолдлын товч утга		Агаарын хөлгийн эвдрэл	
2	Урьдчилсан шалтгаан, нөхцөл байдал		Нислэгт тэнцэх чадвартай холбоотой асуудал	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
3	Нислэгийн үе шат		Хүний хохирол	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
4	Нийтлэг сонирхлын асуудал		Аюултай ачааны мэдээлэл	

V. ICAO / ADREP ИЛГЭЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Үзүүлэлт	Мэдээлэл бөглөх хэсэг
1	ICAO системд оруулсан огноо	
2	ICAO системд оруулсан ажилтан	
3	ID / Лавлага	
4	Хавсаргасан баримт бичиг	

VI. БАТАЛГААЖУУЛАЛТ

№	Үзүүлэлт	Мэдээлэл бөглөх хэсэг	Үзүүлэлт	Мэдээлэл бөглөх хэсэг
1	Бэлтгэсэн ажилтан		Хянасан ажилтан	
2	Албан тушаал		Албан тушаал	
3	Гарын үсэг		Гарын үсэг	
4	Огноо		Огноо	